



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



JAPAN INTERNATIONAL
COOPERATION AGENCY

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог

ДЭМЖИХ ТӨСӨЛ (DPUB)

Мэдээллийн эмхэтгэл №20

(2018.10.15) Хөгжлийн бэрхшээл ба боловсрол,
Оги Наоки багш төслийн үйл ажиллагаатай танилцлаа.

Монголчууд сайн мэдэхгүй байж магадгүй ч Японд “Оги Мама” нэрээрээ олон танигдсан боловсрол судлаач, шүүмжлэгч Оги Наоки багш DPUB төслийн үйл ажиллагаатай танилцлаа. Багшийн блог, бичлэгийг урьдчилан үзэж, 2 ч номыг нь худалдан авч уншаад бэлтгэл ажлыг хангалттай хангасан гэж бодсон боловч яг нүүр тулаад уулзахаар нэлээд сандарч, чөлөөтэй ярьж чадсангүй. Гэхдээ хамгийн сүүлд нь багш “Олон шинэ мэдээлэл олж авч чадлаа” гэж сэтгэгдлээ хуваалцсан учраас бага зэрэг сэтгэл хангалуун байна. Үнэнийг хэлэхэд бид багшийн ярианаас олон зүйлийг суралцсан ба ялангуяа “Клиник боловсрол”-ын тухай яриа сонирхол татлаа. Боловсрол судлаачдын олонх нь судалгаагаа практикт хэрэгжүүлдэггүйн улмаас боловсролын салбар дахь ажил, судалгаа хоёрын хооронд зөрүүтэй тал байдаг байна. Тийм учраас багш боловсролын үзэл баримтлал, практик дахь хэрэгжилт хоёрыг холбон ажиллах гүүр нь болох зорилгоор “Солонго” Клиник боловсрол судалгааны газрыг байгуулжээ. Хэрэгжилтийг ханган ажиллах нь нэлээд хүндрэлтэй хэцүү ажил байх аа гэж бодсон боловч багш өнөөг хүртэл олон сургууль дээр ажиллаж, хичээл заан, жишиг үйл ажиллагаануудыг зохион байгуулсаар иржээ. Ямар нэг асуудалтай анги Оги Мама багшийн хичээлээр дамжуулж асуудлаа шийдэхээс гадна багш нар ч гэсэн практик дахь хэрэгжилтээс олон шинэ зүйлийг олж хардаг болов уу гэж бодож байна. Хөгжлийн бэрхшээлийн салбарт ч гэсэн үзэл баримтлал, судалгаа төдийгүй практик дахь хэрэгжилт, бодлого сайн байснаар ХБИ-ийн нийгмийн оролцоо нэмэгдэнэ. Энэ утгаараа бидний хувьд практик дахь хэрэгжилтийн тал дээр дутагдалтай зүйлүүд байгаа юм байна гэдгийг эргэцүүлж тунгаасан нэг өдөр боллоо. Уулзалтын төгсгөлд Оги Мама багшид Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбооны хийсэн энгэрийн зүүлтийг дурсгал болгон өгсөн ба багш талархан хүлээж авлаа. Багшийн цуглуулганд гэр хэлбэртэй энгэрийн зүүлт нэмэгдсэнд бид ч маш их баяртай байна.



Оги Мама “нооз”

JICA DPUB фэйсбүүк хуудсанд LIKE дарж нэгдээрэй!!

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **3400** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.



Одгэрэл багшдаа баяр хүргэе. (2018.10.10)

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын тухай “Тусгай боловсрол” номыг миний хүндэлж явдаг МУБИС-ийн профессор багш Одгэрэл бичиж гаргалаа. Манай төсөл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролтой шууд хамааралгүй ч, төсөлд хандан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тэдний боловсролын талаар асуух, тодруулах тохиолдол байдаг. Иймд монгол хэлээрх гарын авлага, зөвлөмж ном байвал их хэрэгтэй юм гэж боддог байсан маань биелэлээ оллоо. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хандах ойлголт, дэмжиж туслах арга нь салбарын хүрээнд ч тэр Монголд хараахан нийтлэг танигдаагүй байна. Тус номны ачаар МУБИС-ийн оюутнууд төдийгүй тусгай сургуулийн багш нар болон холбогдох хүмүүс, төрийн албан хаагчид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүл, хамаатан садан, найз нөхөд гээд маш олон хүмүүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх ойлголт мэдлэг нэмэгдэнэ гэж бодож байна. Олон хүмүүсийн талархалыг хүлээгээд буй тус ном нь Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ирээдүйг өөрчлөхөд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна. Одгэрэл багшид чин сэтгэлээсээ талархал илэрхийлье. (JICA/DPUB ахлах зөвлөх Чича Хисао)



Одгэрэл багштай хамт

DPUB Холбоо барих хаяг

Хаяг:

Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас:

<https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас:

<https://www.jica.go.jp/project/mon-golia/015/index.html>

И-мэйл:

dpub.jica@gmail.com

**Дадлагын оюутан
Цэцэнгоогийн
тэмдэглэл**

10-р сарын 8. Өнөөдөр Монгол Японы төвд зохион байгуулагдсан “Мэдээлэл түгээх хэрэгсэл DAISY-ийн танилцуулга өдөрлөг~сонсоод унших ном”-г туршицгаая!~” сэдэвт арга хэмжээнд оролцлоо. DAISY гэдэг нь Digital Accessible Information System гэсэн үгүүдийн товчлол бөгөөд DAISY-ийн ачаар хүн болгон номыг шимтэн унших боломжтой. Би өнөөдөр анх удаа DAISY номтой танилцлаа. Товчхоноор тайлбарлавал зураг, хадмал бичиг, аудио тайлбартайгаас гадна уншиж байгаа хэсэг нь тодордог учраас маш ойлгомжтой. Өнөөдрийн оролцогчид ч гэсэн өөрсдөө уншиж үзээд их гоё бас ойлгомжтой юм аа гэцгээж байлаа. Энэхүү DAISY ном нь Монгол улсад дэлгэрээд удаагүй байгаа боловч үүгээр дамжуулж номын сайн сайхныг ХБИ төдийгүй бүх хүнд мэдрүүлэхийг хүсэж байна. Номонд дуртай, номын гайхамшгийг бусдад түгээх хүсэлтэй та бүхэн заавал сонирхон үзээрэй. Тус номыг Монгол • Японы төвийн номын сангаас үзэх боломжтой! Мөн DAISY-ийн талаарх мэдээллийг бусаддаа түгээхийг хүсэж байна.



Оролцогчид DAISY номнуудыг сонирхон уншлаа.

9-р сарын 28-нд LEAD MONGOLIA хөтөлбөрийн оролцогчид Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-д хамрагдлаа. Би өмнө нь тус сургалттай холбоотой бичлэг үзэж байсан хэдий ч өөрийн биеэр оролцож үзэхэд илүү сайхан санагдлаа. Сургалтын үеэр оролцогч бүр сэдвийн дагуу тунгаан бодож, мөн багаараа ярилцаж аливаа зүйлийг олон талаас нь харж, хэлэлцүүлэг өрнүүлж байв. Мөн нэг багт нэг сургагч багш хуваарилагдсан байсан учир хоорондоо ярилцаж, хөгжлийн бэрхшээл болон ХБИ-ийн талаар бодож, зөв ойлголттой болон улмаар хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааны төлөвлөгөө хүртэл гаргаж байсан. Би энэ удаагийн сургалтанд оролцож үзээд цаашид илүү олон хүнийг энэ сургалтанд оролцож хөгжлийн бэрхшээл болон ХБИ-ийн талаар зөв ойлголттой болоосой гэж хүсэж байна. Сургалт дуусах үед оролцогчид алга нижигнүүлэн ташиж, сургагч багш нарт талархал илэрхийлэв.



DET, Оролцогчид багаараа хэлэлцүүлэг өрнүүлж байна.

10-р сарын 12. Өнөөдөр дадлагын хамгийн сүүлийн өдөр байлаа. Энэ өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт бүтэн өдрийн турш зохион байгуулагдсан семинар болон Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-д оролцов. Бид өмнөх өдөр нь семинарын материал, бэлтгэл ажил зэргээ хангасан байсан тул семинар, DET сургалт амжилттай зохион байгуулагдав. Үдээс өмнөх семинараар “Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл” болон тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр ажиллаж буй START төслийн үйл ажиллагааг танилцууллаа. Оролцогчид тэмдэглэл хөтлөнгөө маш идэвхтэй сонсож байв. Үдээс хойшийн DET сургалтанд би анх удаа оролцлоо. Энэ дашрамд тус сургалтанд өөрийн биеэр сууж үзэх нь хамгийн оновчтой гэдгийг дурдахыг хүсэж байна. Би өмнө нь энэ сургалтанд ажиглагчаар оролцож байсан бол өнөөдөр оролцогчийн хувиар олон зүйлийн талаар тунгаан бодож, мөн сургагч багштай санал солилцож ярилцсан нь миний хувьд сайн туршлага болж чадлаа. Мөн оюутан хүнийхээ зүгээс юу хийх боломжтой, юу чадах талаараа эргэцүүлэн бодов. Тус сургалтанд хамрагдсандаа үнэхээр баяртай байна. Энэхүү тэмдэглэл нь миний дадлагын хугацаандаа бичсэн хамгийн сүүлийн тэмдэглэл юм. Төсөлд дадлага хийх хугацаандаа маш олон зүйлийг суралцаж чадлаа. Мөн төслийн хамт олон бүгдээрээ найрсаг, хөгжилтэйгээс гадна надад их зүйл зааж өгсөн. Энэ хугацаанд сурсан зүйл, туршлага, мөн та бүхний зөвөлгөөг маргалгүй цаашид хичээх болно. 3 долоо хоног хэдийгээр богино хугацаа боловч та бүхний ачаар үр дүнтэй өдрүүдийг өнгөрөөлөө. Баярлалаа.



Дадлагын ажил амжилттай дууслаа.



Ахлах зөвлөх Чибэ

Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагчид, орон орны төрийн албан хаагчидтай хамтран ажилласан тухай НҮБ-д ажиллах хамгийн том давуу тал нь улс орнуудын хөгжлийн бэрхшээлтэй манлайлагчид болон төр засгийн байгууллагуудтай хамтран ажиллах явдал ч байж магадгүй. Олон улсын хурал зөвлөгөөний оролцогчид нь ТББ болон төрийн байгууллагуудыг төлөөлөн ирдэг тул маш чадварлаг, өөрийн гэсэн онцлогтой хүмүүс байх нь олон. Тэр дундаа орон орны хөгжлийн бэрхшээлтэй манлайлагчидтай хамтран ажилласан туршлага минь миний хувьд том баялаг болсон. Фижи зэрэг Ази номхон далайн арлын орнууд, Энэтхэг, Пакистан зэрэг Өмнөд Ази, Индонези, Малайз гэх мэт Зүүн Өмнөд Ази, мөн Япон, Солонгос, Австрали гээд хөгжингүй орнуудын олон янзын соёл, иргэншил, нийгмийг таньж мэдэж чадсан. Эдгээр орнуудын хөгжлийн бэрхшээлтэй манлайлагчид нийгмийн орчинд асуудал байна, сургууль болон ажлын байран дээр ялгаварлан гадуурхагдаж байгаа учраас нийгмийн тэгш оролцоо хангагдахгүй байна, мөн бусдаар өрөвдүүлэх бус эрхээ эдлэхийг хүсэж байна хэмээн өөрсдийн дуу хоолойг хүчтэй илэрхийлж байсан нь сэтгэлд хүрч байв. Тэд өөрсдөдөө итгэлтэй, түүнчлэн мөрөөдөл, эрхэм зорилготой байсан юм. Мөн олон олон төрийн албан хаагчид, мэргэжилтнүүдээс урам зориг авч байлаа. Мэдээлэл технологийн салбарын туршлагатай ч хөгжлийн бэрхшээлийн салбарын мэдлэг ойлголт дутмаг миний хувьд эхэндээ хурал зөвлөгөөний агуулгыг бүрэн ойлгоход хүндрэлтэй байв. Тиймээс дарга, мэргэжилтнүүдийн үгийг сайн сонсож, юу нь чухал болоод юу хийх ёстойгоо хурал зөвлөгөөнд оролцох явцдаа суралцаж байлаа. Ингээд нэг мэдэхэд хөгжлийн бэрхшээлийн салбарт татагдан орох болсон юм. (Үргэлжлэл бий...)